




Banking & Finance
Academy

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2021 оны эхний хагас жилийн тайлан

ГАНЦ ДАЙЧИН ГАНЦААРДАХГҮЙ



ГАНЦ ДАЙЧИН ГАНЦААРДАХГҮЙ...



Банкны салбарын 2021 оны эхний хагас жилийн тоймыг товчоор илэрхийл гэвэл ГАНЦ ДАЙЧИН ГАНЦААРДАХГҮЙ гэх үг яг тохирохоор байна. Цар тахлын цаг үед Засгийн газраас эдийн засгийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр зарласан. Харин үүнийг нь санхүүгийн системийг бүрдүүлэгч банкны салбар өөр дээрээ дааж, хэрэгжүүлэхээр болсон билээ.

Эдийн засгийг дэмжих 10 их наяд төгрөгийн хөтөлбөрийн хэрэгжилт 30 хувьтай үргэлжилж байна. Бүгд л банкны системиээр дамжин хэрэгжсэн. Эхний хагас жилд банкны зээлийн үлдэгдэл 10 хувь өсөж, зээл олголт 57 хувь өссөнөөс харахад эдийн засгийг ганц дэмжиж буй хөрөнгө оруулалт банкны зээл л байлаа.


Нөгөө талдаа төсвийн зарцуулалт нь Ковидын үед халамжаар дамжин эрэлтийг дэмжиж байна. Эргээд өрхүүдийн худалдан авалт нь ААН-үүдийг дэмжих байдлаар эдийн засгаа босгох боломжийг бий болгох учиртай. Гэсэн хэдий ч дотоодын цар тахлын нөхцөл байдал хүнд хэвээр байна. Мөн түүхий эдийн экспорт хийх гол боомт энэ нөхцөл байдлаас болж түр хаагдав. Харин яг ийм үед банкны салбараар дамжин хэрэгжүүлж буй бодлого л эдийн засагт амин тариа болж байна.

2021 оны 2-р улиралд бизнесийн зээл олголт нэмэгдсэн байна.

Эдийн засгийг дэмжих 10 их наядын хөтөлбөрийн зээлийн нөлөөгөөр бизнесийн зээл олголт нэмэгджээ.

↑
Онцлох өөрчлөлт, энгийн тайлбар

Иргэдийн зээл олголт, жил бүрийн 2-р улирлаар харуулав.



Онолын тодорхойлолт

Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

+57%

Бизнесийн зээл олголт, жил бүрийн 2-р улирлаар харуулав.

2021 оны 2-р улирлын гүйцэтгэл

Шинээр олгосон зээлийн хэмжээ 2021 оны 2-р улиралд 57 хувиар өсөв.




2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Эдийн засгийг дэмжих 10 их наяд төгрөгийн хөтөлбөрийн хүрээнд 3 хувийн хүүтэй зээл болон 9 хувийн репо санхүүжилтийн нөлөөгөөр нийт зээл өсөж байна.



Зээлийн чанарын хувьд, системийн хэмжээнд 10 зээл тугмын 1-нь чанаргүйтсэн байна. Ялангуяа иргэдийн зээлийн багц аажмаар муудаж байна.



Ковидоос хойшхи 4 удаагийн хөл хорионы нөлөөгөөр хугацаа хэтэрсэн зээл өсөж байсан бол цаашид буурах төлөвтэй байна.



Банкуудын санхүүгийн үзүүлэлтийг харвал зээл, эх үүсвэр өсөлттэй. Санхүүгийн харьцаа үзүүлэлтээ хангаж байна.



Эдийн засгийн сэргэлт, идэвхжил удааширсан нөхцөлд банкуудын зээлийн чанарт сэргөөр нөлөөлөхөөр байна. Ялангуяа хэрэглээний зээл дээр хүчтэй нөлөөлөх төлөвтэй байна.



Ирэх 1 жилийн хугацаанд системийн нөлөө бүхий банкууд IPO хийхээр байгаа зэрэг нь цар тахлын энэ үед томоохон сорилт болохоор байна.

ЦАР ТАХЛЫН ҮЕ ДЭХ БАНКНЫ САЛБАРЫН ОРЧИН

2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.


+10%

Зээлийн үлдэгдэл дунджаар 10 хувиар өсөв.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Он гарсаар зээлийн үлдэгдэл тасралтгүй өсөж байна.

10 их наяд төгрөгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр нь 30 хувийн биелэлттэй байна. Тус бодлогын нөлөөгөөр банкны зээлийн үлдэгдэл он гарснаас хойш өссөөр байгаа юм.




2021 оны 2-р улиралд бизнесийн зээл олголт нэмэгдсэн байна.


Эдийн засгийг дэмжих 10 их наядын хөтөлбөрийн зээлийн нөлөөгөөр бизнесийн зээл олголт нэмэгджээ.

Иргэдийн зээл олголт, жил бүрийн 2-р улирлаар харуулав.

Тэрбум ₮



Бизнесийн зээл олголт, жил бүрийн 2-р улирлаар харуулав.



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.


+57%

Шинээр олгосон зээлийн хэмжээ 2021 оны 2-р улиралд 57 хувиар өсөв.


Хэрэглээний зээлийн багцын чанар муудаж байна.

Өрхийн орлого өсөхгүй байгаа, ажилгүйдэл нэмэгдсэн нь хэрэглээний зээлийн чанарт сөргөөр нөлөөлж байна. Бизнесийн зээлийн хувьд, ХАА, Уул уурхай болон Боловсруулах салбарын 4 зээл тугмын 1 нь чанаргүйтэж байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн 2-р улирлаар харуулав.



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн 2-р улирлаар харуулав.



Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

10.3%

2021 оны 2-р улирлын байдлаар 10 зээл тугмын 1-нь чанаргүйтсэн байна.

Банкны зээлийн хугацаа хэтрэлт

Жич: 16-90 хоног хүртэлх хугацаа хэтэрсэн зээлийг хэлнэ.

6.2%

2021 оны 2-р улирлын
байдлаар нийт зээлийн багцын
6.2 хувь нь хугацаа хэтэрсэн
байна.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

2021 оны 2-р улиралд бизнесийн хугацаа хэтэрсэн зээл өсөх хандлагатай байна.

Бизнесийн хугацаа хэтэрсэн зээл нэмэгдэх хандлагатай байна.



Валютын ханшийн тогтвортой байдал, зарим журмын өөрчлөлтийн нөлөөгөөр төгрөгийн хадгаламж жилийн 36 хувиар өсжээ.

Хадгаламжийн хүү буурсан ч хугацаагүй хадгаламжид хүү тооцохоо байж, тусгай хадгаламжийн хүүг цуцалсан, валютын ханш тогтвортой байсан зэрэг шалтгаанаас төгрөгийн хадгаламж руу хөрвүүлэлт хийгдэв.

Харилцах, хадгаламжийн дүн, 2021 оны эхний хагас жилийн байдлаар

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

+36%

Төгрөгийн хадгаламж жилийн
36 хувиар өссөн.

Банкны системийн долларжилт

Жич: Хадгаламж болон зээлийн хэдэн хувийг валютын эх үүсвэр болон зээл бүрдүүлж байгааг тодорхойлдог.


25%

Эх үүсвэрийн долларжилт 2021 оны 2-р улирлын байдлаар 25 хувьтай байна.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо


2020 оны 9-р сараас эхлэн эх үүсвэрийн (хадгаламж, харилцах) долларжилт буурах хандлагатай байна

Ам.долларын ханш сүүлийн 2 жил төгрөгийн эсрэг чангарсантай холбоотой валютаар зээл гаргах банкуудын сонирхол буурав. Улмаар нийт зээлд валютын зээлийн эзлэх хувь тасралтгүй буурчээ.



Хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг оруулсан зээлийн жигнэсэн дундаж хүү 12 хувьтай байна.

2020 оноос хойш хадгаламжийн хүү 4.5 нэгж хувиар буурсан бол зээлийн хүү 2.2 нэгж хувиар буураад байна.



Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

6.1%

Шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү буурсан байна.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН
ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэл



2021 оны эхний хагас жилийн байдлаар, системийн нөлөө бүхий топ 5 банкны актив өсөлттэй байна.

Системийн нөлөө бүхий банкуудын актив сүүлийн 3 жил өсөлттэй байна. Тус өсөлтийн ихэнх хувийг банкуудын эзэмшиж буй Төв банкны үнэт цаасны өсөлт бүрдүүлж байна.

Банкны нийт актив, 2021 оны эхний хагас жилийн байдлаар харуулав.

их наяд төгрөг




2019	2020	2021H1	2019	2020	2021H1	2019	2020	2021H1	2019	2020	2021H1	2019	2020	2021H1
Хаан			Голомт			ХХБ			Хас			Төрийн банк		


2021 оны эхний хагас жилийн байдлаар, системийн нөлөө бүхий 5 банкны зээлийн багц өсөлттэй байна.

2020 онд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан банкуудын зээлийн багц бууралттай байсан бол 2021 он гарсаар зээлийн багцууд өссөн байна. Үүнд, 10 их наядын хөтөлбөрын зээл голчлон нөлөөлжээ.

Банкны нийт зээл, 2021 оны эхний хагас жилийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан






2021 оны эхний хагас жилийн байдлаар системийн нөлөө бүхий топ 5 банкны эх үүсвэр өсөлттэй байна.

Банкны хадгаламжийн хүү буурсан хэдий ч иргэд, ААН-ийн банкны хадгаламжид итгэх итгэл хэвээр байна.


Банкны нийт эх үүсвэр, 2021 оны эхний хагас жилийн байдлаар харуулав.



2021 оны эхний хагас жилийн байдлаар, системийн нөлөө бүхий топ 5 банкны өөрийн хөрөнгө өссөн байна

Банкуудын өөрийн хөрөнгийн үзүүлэлт сүүлийн 3 жил өсөх хандлагатай байна.

Банкуудын өөрийн хөрөнгө, 2021 оны эхний хагас жилийн байдлаар харуулав.




Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан



Системийн нөлөө бүхий топ 5 банкны зээлийн багц өссөн нь чанаргүй зээлийн харьцаа буурах шалтгаан болов.

Төрийн банкнаас бусад банкуудын чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт буурсан дүр зурагтай байна. Зээлийн чанар хамгийн сайн байгаа нь Хаан банк, Хасбанк зэрэг иргэдэд голдуу үйлчилдэг банкууд байна.

Банкны чанаргүй зээлийн харьцаа, 2021 оны эхний хагас жилийн байдлаар харуулав.




Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан





Системийн нөлөө бүхий 5 банкны өөрийн хөрөнгө хангалттай байгаа ч цаашид буурах хандлагатай байгаа нь банкуудын эдийн засгийг дэмжих бодлоготой холбоотой.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, 2021 оны эхний хагас жилийн байдлаар харуулав.




2019	2020	2021H1	2019	2020	2021H1	2019	2020	2021H1	2019	2020	2021H1	2019	2020	2021H1
Хаан			Голомт			ХХБ			Хас банк			Төрийн банк		

Системийн нөлөө бүхий 5 банк нь хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийг хангаж байна.

Цар тахал гарсантай холбоотой хөтөлбөрийн зээлээс бусад зээлийн олголт өсөхгүй байна. Улмаар бүх банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Хөрвөх чадварын харьцаа, 2021 оны эхний хагас жилийн байдлаар харуулав.



2019	2020	2021H1	2019	2020	2021H1	2019	2020	2021H1	2019	2020	2021H1	2019	2020	2021H1
Хаан			Голомт			ХХБ			Хас банк			Төрийн банк		

ЦАР ТАХЛЫН ҮЕ ДЭХ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН


2021 оны эхний хагас жил: Гадаад орчин талаас түүхий эдийн үнэ сэргэсэн ч дотоодын цар тахалтай холбоотой экспорт саатаж байна. Өөрөөр хэлбэл, гадаад зах зээлийн өсөлтийг бид хүртэж чадахгүй байна. Бизнесийн байгууллагуудын 70 гаруй хувь нь санхүүгийн хүндрэлд орсон, өрхүүдийн орлого 4 хувиар агшсан, төсвийн алдагдал 1.4 их наяд төгрөгт хүрсэн, өдөрт 2000 машин нүүрсний экспорт хийдэг боомтоор 200 машин гарч байгаа зэргээс нөхцөл байдал ямар байгааг харж болохоор байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлтийн 90 хувь нь уул уурхай, бүтээгдэхүүний цэвэр татвараас бий болжээ. Хэдийгээр вакцинжуулалт хурдтай хийгдсэн ч дотоодын халдварын тоо төдийлөн буурахгүй байгаа нь салбарын сэргэлтийг удаашруулж байна.

Төлөв байдал: Уул уурхайн бус салбаруудад сэргэлт, өсөлт төдийлөн ажиглагдахгүй байна. Түүнчлэн гаалийн хязгаарлалттай холбоотой импортын бараа гацаж, тэр нь он дуустал үргэлжлэхээр байна. Хэдийгээр ам.долларын ханш тогтвортой байгаа ч энэ нь тээврийн зардлын өсөлтөөр дотоодын барааны үнийг өсгөж байна. Цаашдын төлөв байдлыг харвал 2022 оны эхний хагасаас л эдийн засаг сэргэж эхлэхээр байна. Мөн хугацаанд инфляц өсөх хүлээлттэй байгаа ч ам.долларын ханш, хүү тогтвортой байхаар байна.

2021 оны эхний хагас жилд уул уурхайн салбар 24.3 хувиар өсөв.


Он гарсаар түүхий эдийн үнэ огцом өсөлтийн нөлөөгөөр уул уурхайн салбар сэргэсэн ч 2 дугаар улиралд экспортод тавьсан хязгаарлалт нь салбарын өсөлтийг удаашруулав. Дотоод эрэлт буурсан, цагийн болон үйлчлүүлэгчийн тооны хязгаарлалт нь уул уурхайн бус салбарын сэргэлтийг удаашруулж байна.




2021 оны 2-р улиралд дотоодын халдвар их байгаа нь боомтын гарцыг багасгаж, экспортын өсөлтийг сааруулав.

- Түүхий эдийн үнэ 30-50 орчим хувиар өссөн хэдий ч нүүрсний тоо хэмжээ хэвийн үетэй харьцуулахад 50 хувиар буураад байна.
- Импорт идэвхжиж байгаа ч гааль дээр үүссэн ариугалтай холбоотой хязгаарлалт сөргөөр нөлөөлсөн хэвээр байна.


Экспортын огцом өсөлт 2-р улиралд саарлаа.



Гаалийн хязгаарлалт импортын өсөлтөд сөргөөр нөлөөлөв.




Импортын хязгаарлалтаас худалдааны тэнцэл ашигтай гарав.




Ханш тогтворжиж байгаа ч инфляцийн дарамт их байна.

- Түүхий эдийн үнийн өсөлт, Импортын хязгаарлалт, дотоодын эдийн засгийн идэвхжил бага байгаа нь ханш тогтвортой байх шалтгаан болж байна. Улмаар валютын нөөц 9 сарын импортыг хангах түвшинд ирэв.
- Гэсэн хэдий ч дотоодод хүнсний инфляц 12 хувьд хүрч, хатуу түлш болон шатахууны үнийн өсөлт нь инфляцид дарамт болж байна.


Түүхий эдийн үнийн өсөлт нь экспортыг дэмжиж **валютын ханш** тогтвортой байна.




Импортын 9 сарын нөөцийг хангахуйц **валютын албан нөөцтэй** байна.



Эдийн засгийг дэмжих бодлогын хүрээнд **бодлогын хүү** он дуустал тогтвортой байхаар байна.




Хүнс, хатуу түлш, шатахууны үнийн өсөлт **инфляцид** хүчтэй нөлөөлж байна.




2021 оны 7 дугаар сарын байдлаар төсвийн тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтай байна.

Эдийн засгийг дэмжих 10 их наядын хөтөлбөр 30 хувийн биелэлттэй явж байна. Түүнчлэн он дуустал Засгийн газраас хэрэгжүүлж буй хүүхдийн 100 мянган төгрөг, тог цахилгааны хөнгөлөлт гэх мэт хөтөлбөрийг үргэлжлүүлэхээр болсон нь төсвийн алдагдлыг оны төгсгөлд нэмэгдүүлэхээр байна.

Төсвийн орлого, их наяд төгрөг



Төсвийн зарлага, их наяд төгрөг



Төсвийн алдагдал, их наяд төгрөг

